



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 1/145

Батноров сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам"-ын 11.10 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захирагчийн 2024 оны А/40 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон 2 (хоёр) малчдын хоршоонд хавсралтад заасан газрыг эзэмшүүлсүгэй.

2. Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээг баталгаажуулахыг Газрын даамал (Т.Очирбат)-д үүрэг болгосугай.

3. Газрыг зориулалтын дагуу ашиглаж, гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд газрын төлбөрийг хугацаанд төлөхийг газар эзэмшигч малчдын хоршоо тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЖАВХЛАНБАЯР



230423343